


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН
ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО
БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

Гадаад худалдааны нийт бараа эргэлт:
2025 оны эхний 2 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 3,715.8 сая ам.доллар болж 2024 оны мөн үеэс 120.4 сая ам.доллар буюу 3.1 хувиар буурчээ. Экспортын дүн импортын дүнгээс 294.0 сая ам.доллараар

давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа. Гадаад худалдааны нийт бараа эргэлт буурсан нь Монгол Улсын гол эрдсийн бүтээгдэхүүнүүдийн үнийн уналтаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 2 сар				Өөрчлөлт	
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	2,217.9	3,441.7	3,836.2	3,715.8	-120.4	-3.1
-Экспорт	1,180.2	2,243.5	2,240.3	2,004.9	-235.4	-10.5
-Импорт	1,037.7	1,198.2	1,595.9	1,710.9	115.0	7.2
Тэнцэл	142.5	1,045.3	644.4	294.0	-350.4	-54.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **294.0** сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 350.4 сая ам.доллараар буюу 54.4 хувиар буурсан байна.

Экспорт: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр экспортод **2,004.9** сая ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Импорт: 2025 оны эхний 2 сард импортоор нийт **1,710.9** сая ам.долларын бараа, түүхий эд оруулсан нь 2024 оны мөн үеэс 115.0 сая ам.доллараар буюу 7.2 хувиар өссөн байна.

Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Монгол Улс дэлхийн 49 оронд бараа экспортлосноос **БНХАУ-д 89.3** хувь, Швейцар-т 7.8 хувь, АНУ-д 0.5 хувь, ОХУ-д 0.5 хувь тус тус ногдож нийт экспортын **98.2** хувийг дээрх орнууд эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 15.4 хувиар буурсан нь Монгол Улсын гол экспортын бүтээгдэхүүн болох **нүүрс, газрын тос, төмрийн хүдрийн зах зээлийн үнийн уналтаас** шалтгаалсан байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **1,728.2** сая ам.доллар болж, өмнөх оноос 313.6 сая ам.доллар буюу **15.4 хувиар буурсан** бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **276.7** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 78.3 сая ам.доллар буюу **39.4 хувиар өссөн** байна.

2025 оны эхний 2 сард нүүрсний экспортын дундаж үнэ нэг тонн тутамд **83.8** ам.доллар болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **42.1** ам.доллараар буурсан нь манай улсын экспортын орлого буурахад голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 2 сар				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	849.9	1,923.7	2,041.8	1,728.2	-313.6	-15.4	86.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	330.3	319.8	198.4	276.7	78.3	39.4	13.8
Нийт экспорт	1,180.2	2,243.5	2,240.3	2,004.9	-235.4	-10.5	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 27.6 хувийг зэсийн баяжмал, 42.8 хувийг нүүрс, 4.0 хувийг төмрийн хүдэр, 3.3 хувийг жоншны баяжмал, 2.3 хувийг

түүхий нефть болон газрын тос, 2.0 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 2 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2024	2025	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	253.6	281.1	27.5	10.9
Нүүрс	сая.тн	10.6	10.2	-0.4	-3.5
Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн	1,120.9	1,092.4	-28.5	-2.5
Цайрын баяжмал	мян.тн	7.7	25.2	17.6	229.2
Алт	тн	0.3	1.8	1.5	490.0
Боловсруулаагүй нефть	сая.баррель	0.7	0.6	-0.1	-13.7
Катодын зэс	мян.тн	1.3	1.2	0.0	-2.4
Жоншны хүдэр, баяжмал	мян.тн	188.0	294.8	106.8	56.8
Адууны мах	мян.тн	2.2	2.8	0.6	25.7
Өлөн гэдэс	тн	70.2	308.7	238.5	339.7
Үхэр, адууны боловсруулсан шир	мян.дм2	768.0	453.6	-314.4	-40.9
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	64.6	9.4	-55.2	-85.4
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	-	1.4	1.4	-
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	4.9	2.1	-2.8	-57.3
Ямааны самнасан ноолуур	тн	140.7	59.8	-80.9	-57.5
Ямааны угаасан ноолуур	тн	35.38	-	-35.4	-100.0
Самнаагүй хонины ноос	мян.тн	0.8	0.5	-0.3	-35.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	эхний 2 сар		Өмнөх оны мөн үеэс		Экспортод эзлэх хувь
	2024	2025	Дүн	Хувь	
Зэсийн баяжмал	445.2	553.4	108.2	24.3	27.6
Нүүрс	1,336.5	858.8	-477.6	-35.7	42.8
Төмрийн хүдэр, баяжмал	90.2	79.8	-10.4	-11.5	4.0
Цайрын баяжмал	9.9	39.9	29.9	301.5	2.0
Алт	20.8	164.3	143.5	689.8	8.2
Боловсруулаагүй нефть	54.4	46.1	-8.3	-15.3	2.3
Катодын зэс	10.0	10.8	0.8	8.1	0.5
Жоншны хүдэр, баяжмал	41.6	65.6	24.0	57.8	3.3
Адууны мах	7.9	9.9	2.0	25.9	0.5
Өлөн гэдэс	1.3	2.6	1.4	105.6	0.1
Үхэр, адууны боловсруулсан шир	0.0	0.0	0.0	-61.2	0.0
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.1	0.0	-0.1	-94.3	0.0
Хонь, хурганы боловсруулсан арьс	-	0.0	0.0	-	0.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	0.1	0.0	-0.1	-69.5	0.0
Самнасан ноолуур	14.2	7.0	-7.2	-50.7	0.3
Ямааны угаасан ноолуур	1.6	-	-1.6	-100.0	-
Самнаагүй хонины ноос	0.8	0.7	-0.1	-15.7	0.0
Нийт экспортод эзлэх хувь	90.8	91.7			

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 5. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ

/сая ам.доллар/

Барааны нэр	Хэмжих нэгж	эхний 2 сар		Өөрчлөлт	
		2024	2025	Дүн	Хувь
Чулуун нүүрс	тн/ам.дол	125.9	83.8	-42.1	-33.4
Зэсийн баяжмал	тн/ам.дол	1,755.2	1,968.4	213.2	12.1
Төмрийн хүдэр, баяжмал	тн/ам.дол	80.4	73.0	-7.4	-9.2
Цайрын баяжмал	тн/ам.дол	1,295.1	1,579.5	284.5	22.0
Хайлуур жоншны хүдэр, баяжмал	тн/ам.дол	221.1	222.5	1.4	0.6
Молибдены баяжмал	тн/ам.дол	14,110.7	16,488.5	2,377.8	16.9
Алт	кг/ам.дол	67,028.9	89,525.3	22,496.4	33.6

Эх сурвалж: Сангийн яам, Гаалийн ерөнхий газар

Эрдсийн бүтээгдэхүүний экспортод голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 858.8 сая ам.долларын 10.2 сая.тн нүүрс экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 477.6 сая ам.доллар буюу 35.7 хувиар буурч, биет хэмжээгээр 0.4 сая. тн буюу 3.5 хувиар буурсан байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ 83.8 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.4 хувиар буурсан байна. Нүүрсийг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Зэсийн баяжмал: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 553.4 сая ам.долларын 281.1 мян.тн зэсийн баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 108.2 сая ам.доллараар буюу 24.3 хувиар, биет хэмжээ 27.5 мян.тн буюу 10.9 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн зэсийн баяжмалын экспортын үнэ 1,968.4 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1 хувиар өссөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Төмрийн хүдэр, баяжмал: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 79.8 сая ам.долларын 1,092.4 мян.тн төмрийн хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 10.4 сая ам.доллараар буюу 11.5 хувиар, биет хэмжээ 28.5 мян.тн буюу 2.5 хувиар тус тус буурсан байна. Нэг тонн төмрийн хүдрийн экспортын үнэ 73.0 ам.долларт хүрч өмнөх мөн үеэс 9.2 хувиар буурсан байна. Төмрийн хүдэр, баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Жоншны хүдэр, баяжмал: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 65.6 сая ам.долларын 294.8 мян.тн хайлуур жоншны хүдэр, баяжмал экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 24.0 сая ам.доллараар буюу 57.8 хувиар, биет хэмжээ 106.8 мян.тн буюу 56.8 хувиар тус тус өссөн байна. Нэг тонн жоншны экспортын үнэ 222.5 ам.долларт хүрч өмнөх мөн үеэс 0.6 хувиар өссөн байна. Жоншны 89.5 хувийг БНХАУ, 10.4 хувийг ОХУ руу тус тус экспортолсон байна.

Алт: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 164.3 сая ам.долларын 1.8 тонн алт экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс үнийн дүнгээр 143.5 сая ам.доллар буюу 6.9 дахин, биет хэмжээ 1.5 тонн буюу 4.9 дахин өссөн байна. Нэг кг алтны экспортын үнэ 89,525.3 ам.долларт хүрч, өмнөх мөн үеэс 33.6 хувиар өссөн байна. Алтны 94.8 хувийг Швейцар, 5.2 хувийг АНУ руу тус тус экспортолсон байна.

Газрын тос: 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр 46.1 сая ам.долларын 0.6 сая.бар газрын тос экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс биет хэмжээгээр 0.1 сая.бар буюу 13.7 хувиар, үнийн дүнгээр 8.3 сая ам.доллар буюу 15.3 хувиар тус тус буурсан байна. Газрын тосыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

Экспорт буурахад нөлөөлөл үзүүлсэн хүчин зүйлс:

- Нүүрс, газрын тос болон төмрийн хүдрийн экспортын орлого буурсан нь БНХАУ-ын зах зээл дэх үнийн бууралтаас хамааралтай байна.
- Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын 100 хувь нь БНХАУ руу хийгдэж байна.

Эерэг нөлөөлөл үзүүлсэн хүчин зүйлс:

- Алт, зэсийн баяжмал, жоншны экспортын тоо хэмжээ, үнийн өсөлт нь эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлж байна.

Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн

Импорт: Манай улс дэлхийн 112 орноос гарал үүсэлтэй бараа импортлосноос **БНХАУ-д 30.5** хувь; **ОХУ-д 28.9 хувь**; Япон-д 14.1 хувь; АНУ-д 5.8 хувь; БНСУ-д 3.4 хувь тус тус ногдож байгаа нь нийт импортын дүнгийн **84.8** хувийг эзэлж байна.

Гадаад худалдааны нийт импорт 2025 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр **1,710.9** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 115.0 сая ам.доллар буюу 7.2 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **440.2** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 26.2 сая ам.доллараар буюу 6.3 хувиар өссөн байна.

Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **1,270.6** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 88.8 сая ам.доллар буюу 7.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 6. Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт /сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 2 сар				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2022	2023	2024	2025	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	260.0	305.5	414.0	440.2	26.2	6.3	25.7
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	777.7	892.7	1,181.9	1,270.6	88.8	7.5	74.3
Нийт импорт	1,037.7	1,198.2	1,595.9	1,710.9	115.0	7.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 25.7 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 23.0 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 20.7 хувь, хүнсний бүтээгдэхүүн 6.9 хувь, үндсэн

төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 6.1 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 4.4 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр

/сая ам.доллар/

№	Барааны нэр	эхний 2 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2024	2025	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	18.1	19.8	1.7	9.2	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	33.3	27.0	-6.3	-18.9	1.6
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	7.0	8.0	0.9	12.9	0.5
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	119.1	118.1	-1.0	-0.9	6.9
5	Эрдэс бүтээгдэхүүн	414.0	440.2	26.2	6.3	25.7
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	85.0	74.5	-10.6	-12.4	4.4
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	43.6	48.8	5.2	12.0	2.9
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	1.4	1.4	-0.1	-3.8	0.1
9	Мод, модон эдлэл	9.8	15.1	5.3	54.1	0.9
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	11.9	12.4	0.5	4.4	0.7
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	17.5	16.8	-0.6	-3.7	1.0
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	5.0	5.8	0.8	17.0	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	26.8	29.4	2.6	9.9	1.7
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	0.6	0.9	0.3	60.1	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	90.8	104.6	13.9	15.3	6.1
16	Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг	302.7	354.0	51.2	16.9	20.7
17	Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги	371.1	393.3	22.2	6.0	23.0
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	18.6	20.4	1.8	9.6	1.2
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	19.3	19.3	0.1	0.4	1.1
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.0	0.0	0.0	-53.6	0.0
21	Бусад	0.3	1.1	0.8	270.3	0.1
	ДҮН	1,595.9	1,710.9	115.0	7.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импорт өсөхөд голлон нөлөөлсөн бараа, бүтээгдэхүүн

Суудлын автомашин импорт:

Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 26,267 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,334 ширхэг буюу 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 960 ширхэгээр, бусад суудлын автомашин 374 ширхэгээр тус тус өссөн.

Хүснэгт 8. Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Барааны төрөл	Тоо хэмжээ		Өөрчлөлт		Татварын дүн		Өөрчлөлт	
	2024.II	2025.II	Дүн	Хувь	2024.II	2025.II	Дүн	Хувь
Хос тэжээлт	21,222	22,182	960	4.5	162.8	184.2	21.4	13.2
Бусад	3,711	4,085	374	10.1	53.9	71.1	17.3	32.1
Нийт	24,933	26,267	1,334	5.4	216.7	255.4	38.7	17.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Автомашины импортын өсөлт нь түлшний хэмнэлттэй технологийн хэрэгцээ, бодлогын өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлийн нөлөөгөөр үүсэж байна. Цаашид цахилгаан болон ногоон энергийн тээврийн хэрэгслийн эрэлт нэмэгдэх хандлагатай байна.

Автобензин, дизелийн түлшний импорт:

Монгол Улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2025 оны эхний 2 сард 473.6 мян.тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна. Тус тайлант хугацаанд дизель түлшний импорт 322.9 мян.тн-д болж 33.9 хувиар өссөн бол харин А-80 автобензины импорт 0.1 мян.тн-д хүрч 93.9 хувиар, А-95 автобензины импорт 3.0 мян.тн-д хүрч 26.6 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 9. Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар /тэрбум төгрөг/

Төрөл	Барааны төрөл	Тоо хэмжээ /мян.тн/		Өөрчлөлт		Ногдуулсан татварын дүн		Өөрчлөлт	
		2024.II	2025.II	Дүн	Хувь	2024.II	2025.II	Дүн	Хувь
Автобензин	А-80	2.0	0.1	(1.8)	(93.9)	0.8	0.1	(0.8)	(93.9)
	А-92	147.4	147.6	0.2	0.1	40.5	40.5	0.0	0.1
	А-95 болон түүнээс дээш	4.0	3.0	(1.1)	(26.6)	0.8	2.0	1.2	136.9
Дизель түлш		241.2	322.9	81.8	33.9	101.4	129.5	28.1	27.7
Нийт		394.6	473.6	79.1	20.0	143.5	172.0	28.5	19.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Дээрхээс дүгнэхэд дизель түлшний импортын эрс өсөлт нь уул уурхайн салбарын эрчимтэй үйл ажиллагаа, тээвэрлэлтийн хэрэгцээ нэмэгдсэнтэй холбоотой.

Гаалийн байгууллага нь 2025 оны эхний 2 сард нийт 1,011.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **1,024.2** тэрбум төгрөгийг төвлөрүүлж 101.3 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал нийт орлого 87.6 тэрбум төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 10. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024.II	2025.II		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Орлогын биелэлтийн хувь
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Хувь
Нийт орлого	936.6	1,011.3	1,024.2	87.6	9.4	101.3
Татварын дүн	914.9	987.4	1,004.0	89.1	9.7	101.7
Гаалийн албан татвар	233.2	267.8	265.7	32.5	13.9	99.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	536.6	583.0	571.3	34.7	6.5	98.0
Архи, дарсны онцгой албан татвар	8.9	8.4	11.3	2.4	27.0	134.5
Тамхины онцгой албан татвар	19.0	18.0	21.9	2.9	15.3	121.7
Шар айрагны онцгой албан татвар	1.0	1.4	2.0	1.0	100.0	142.9
Суудлын автомашины онцгой албан татвар	111.0	102.2	126.3	15.3	13.8	123.6
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	0.8	1.5	0.8	0.0	0.0	53.3
Автобензин, дизель түлшний албан татвар	4.4	5.1	4.7	0.3	6.8	92.2
Экспортын татвар	-	-	-	-	-	-
Хураамж	20.2	22.0	17.9	-2.3	-11.4	81.4
Өөрийн орлого	1.5	1.9	2.3	0.8	53.3	121.1

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэл өсөхөд нөлөөлсөн голлох орлогууд:

- Гаалийн албан татвар 32.5 тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртөгийн албан татвар 34.7 тэрбум;
- Архи, дарсны онцгой албан татвар 2.4 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 2.9 тэрбум төгрөг;
- Шар айрагны онцгой албан татвар 1.0 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 15.3 тэрбум төгрөг;
- Автобензин дизелийн түлшний албан татвар 0.027 тэрбум төгрөг;
- Өөрийн орлого 0.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Тав. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татвараас чөлөөлөгдсөн импорт нь 2025 оны эхний 2 сард 213.3 тэрбум төгрөгт хүрч, түүнд ногдуулсан **17.3** тэрбум төгрөгийн татварыг хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.0 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 11. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2024.II		2025.II		Өөрчлөлт	
	Импортын дүн	Чөлөөлсөн татвар	Импортын дүн	Чөлөөлсөн татвар	Импортын дүн	Чөлөөлсөн татвар
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	2.2	0.2	0.0	0.0	-2.2	-0.2
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	16.4	2.5	12.4	1.9	4.1	-0.6
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ болон газрын тосны компаниудын тоног төхөөрөмж	37.6	5.8	30.1	4.7	-7.5	-1.2
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	0.3	0.0	1.2	0.2	1.0	0.2
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	11.0	1.7	40.8	6.3	29.8	4.6
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	15.5	2.4	5.3	0.8	-10.2	-1.6
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	5.8	0.9	8.2	1.3	2.4	0.4
Бусад	147.1	22.7	17.6	2.2	-129.5	-20.5
Нийт	235.9	36.3	115.5	17.3	-112.3	-19.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

